АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хашаат сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** АРА-2026/082/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mnP Эрдэнэбулган хот 2026 он | Дарга, тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа<br>Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalbaat@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860 Цахим хаяг:Nerguibaatard@audit.gov.mn<br>Цахим актив аудит ХХК: Аудитор: Д.Эрдэнэцэцэг<br>Утас:99019943 Цахим хаяг: tsakhimactive@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 128
танай ____________-ны №____________-т

ХАШААТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Б.ДЭМБЭРЭЛСАМБУУ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хашаат сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлын онцлог хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны эм, эмнэлгийн хэрэгслийн үлдэгдэл 19,910.1 мянган төгрөг, үүний 2,096.9 мянган төгрөгийн он дамжсан үлдэгдэл байна.

Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 3620 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж Эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний 60,426.7 мянган төгрөгийн санхүүжилтийн авлага бүртгэж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох санхүүжилтээр 1,147,518.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардалд 42,553.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 1,081,990.1 мянган төгрөгийн зарлага бүртгэж, 76,862.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 37,000.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн газраас 6,496.8 мянган төгрөгийн нийт 43,496.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө,14,674.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад хангамжийн материал үнэ төлбөргүй хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсөв захирагчаас 73.9 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **303,471,860.12** | **220,340,577.17** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 66,676,583.15 | 76,862,782.96 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 66,676,583.15 | 76,862,782.96 |
| **3121** | **Төгрөг** | 66,676,583.15 | 76,862,782.96 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 66,676,583.15 | 76,862,782.96 |
| **33** | **АВЛАГА** | 151,220,421.16 | 60,426,746.07 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 151,220,421.16 | 60,426,746.07 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 85,574,855.81 | 83,051,048.14 |
| **351** | **Түүхий эд материал** | 37,153,108.00 | 27,752,059.33 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,713,000.00 | 1,713,000.00 |
| 35130 | Эм боох материал | 35,440,108.00 | 26,039,059.33 |
| **354** | **Хангамжийн материал** | 48,421,747.81 | 55,298,988.81 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 638,000.00 | 638,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 47,045,509.81 | 51,937,681.81 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1.00 | 1.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 257,000.00 | 2,137,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 481,237.00 | 586,306.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **651,464,858.38** | **632,932,345.45** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 651,464,858.38 | 632,932,345.45 |
| **392** | **Биет хөрөнгө** | 642,992,858.38 | 624,460,345.45 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 574,836,425.14 | 574,836,425.14 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (80,285,901.63) | (95,564,301.82) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 55,040,560.00 | 55,040,560.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (24,811,095.92) | (34,195,198.56) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 185,192,163.34 | 172,019,829.64 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (89,070,038.57) | (84,448,587.20) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 31,947,793.40 | 49,914,649.47 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (16,639,237.88) | (18,189,074.12) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 22,779,076.00 | 20,279,076.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (16,273,885.50) | (15,510,033.10) |
| 39217 | Ном | 277,000.00 | 277,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 8,472,000.00 | 8,472,000.00 |
| 39301 | Програм хангамж | 460,000.00 | 460,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (460,000.00) | (460,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,472,000.00 | 8,472,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **954,936,718.50** | **853,272,922.62** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **954,936,718.50** | **853,272,922.62** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 954,936,718.50 | 853,272,922.62 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 362,059,153.42 | 362,059,153.42 |
| 51101 | Өмч: - төрийн | 362,059,153.42 | 362,059,153.42 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 407,397,608.62 | 305,733,812.74 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 407,397,608.62 | 407,397,608.62 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (101,663,795.88) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 185,479,956.46 | 185,479,956.46 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **954,936,718.50** | **853,272,922.62** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,016,542,158.35** | **1,037,318,505.49** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **983,042,158.35** | **1,037,318,505.49** |
| **120017** | Үнэ төлбөргүй хүлээн авсан ҮХ | | 6,496,836,07 |
| **120018** | Үнэ төлбөргүй хүлээн авсан БМ | | 14,674,142,.42 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 47,210,820.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 47,210,820.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 24,256,200.00 | 51,957,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 24,256,200.00 | 51,957,400.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 958,785,958.35 | 938,150,285.49 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 958,785,958.35 | 938,150,285.49 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **875,182,562.81** | **1,138,982,301.37** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **875,182,562.81** | **1,101,982,301.37** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 870,990,629.02 | 1,015,235,446.63 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 594,701,915.20 | 701,215,976.87 |
| 210101 | Үндсэн цалин | 353,880,212.00 | 348,641,891.03 |
| 210102 | Нэмэгдэл | 173,523,279.20 | 268,893,391.84 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,142,000.00 | 25,800,000.00 |
| 210104 | Урамшуулал | 54,156,424.00 | 57,880,694.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 70,396,337.91 | 85,159,242.47 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,170,554.59 | 61,804,675.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,979,753.28 | 7,293,838.01 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,879,591.09 | 3,551,225.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,010,811.45 | 2,501,847.26 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,355,627.50 | 10,007,656.67 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,390,566.21 | 34,192,584.20 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,070,782.11 | 4,602,666.64 |
| 210302 | Түлш, халаалт | 15,059,634.10 | 26,903,967.56 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,260,150.00 | 2,685,950.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 40,794,701.00 | 49,406,258.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,941,600.00 | 5,177,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,581,280.00 | 25,382,120.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,793,600.00 | 2,093,465.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 510,100.00 | 30,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,968,121.00 | 16,723,173.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 65,992,004.73 | 42,811,310.09 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 57,333,551.73 | 36,801,589.09 |
| 210502 | Хоол, хүнс | 6,388,453.00 | 6,009,721.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 17,739,200.00 | 6,856,860.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,739,200.00 | 6,856,860.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,960,000.00 | 9,122,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,960,000.00 | 9,122,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,951,300.00 | 17,330,166.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 743,800.00 | 15,102,666.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 1,500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 79,500.00 | 79,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 85,000.00 | 109,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 510,000.00 | 539,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 55,064,603.97 | 69,140,449.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,783,750.00 | 7,111,100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 46,280,853.97 | 62,029,349.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,191,933.79 | 86,746,854.74 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 71,982,038.94 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 36,150,038.94 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 8,484,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 27,348,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,191,933.79 | 14,764,815.80 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,191,933.79 | 14,764,815.80 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **37,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 37,000,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | | 37,000,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **141,359,595.54** | **(101,663,795.88)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **141,359,595.54** | **(101,663,795.88)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **875,374,696.19** | **1,106,941,202.09** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **841,874,696.19** | **1,106,941,202.09** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 47,210,820.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 47,210,820.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 24,256,200.00 | 51,957,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 24,256,200.00 | 51,957,400.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 817,618,496.19 | 1,007,772,982.09 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 817,618,496.19 | 1,007,772,982.09 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **818,841,683.61** | **1,059,755,002.28** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **818,841,683.61** | **1,059,755,002.28** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **814,649,749.82** | **973,008,147.54** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 594,701,915.20 | 701,215,976.87 |
| 210101 | Үндсэн цалин | 353,880,212.00 | 348,641,891.03 |
| 210102 | Нэмэгдэл | 173,523,279.20 | 268,893,391.84 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,142,000.00 | 25,800,000.00 |
| 210104 | Урамшуулал | 54,156,424.00 | 57,880,694.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 70,396,337.91 | 85,159,242.47 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,170,554.59 | 61,804,675.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,979,753.28 | 7,293,838.01 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,879,591.09 | 3,551,225.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,010,811.45 | 2,501,847.26 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,355,627.50 | 10,007,656.67 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 15,709,566.21 | 34,192,584.20 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,070,782.11 | 4,602,666.64 |
| 210302 | Түлш, халаалт | 10,378,634.10 | 26,903,967.56 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,260,150.00 | 2,685,950.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 37,093,630.00 | 46,294,335.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,024,600.00 | 5,177,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,959,680.00 | 24,925,720.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,793,600.00 | 2,093,465.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 510,100.00 | 30,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,805,650.00 | 14,067,650.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 60,657,450.50 | 62,257,283.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 52,329,345.50 | 50,422,493.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,058,105.00 | 6,114,790.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,270,000.00 | 5,720,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 20,774,200.00 | 10,324,860.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,996,200.00 | 10,324,860.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,960,000.00 | 9,062,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,960,000.00 | 9,062,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,951,300.00 | 17,390,166.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 743,800.00 | 15,162,666.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 1,500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 79,500.00 | 79,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 85,000.00 | 109,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 510,000.00 | 539,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9,405,350.00 | 7,111,100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,405,350.00 | 7,111,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,191,933.79** | **86,746,854.74** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 71,982,038.94 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 36,150,038.94 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 8,484,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 27,348,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,191,933.79 | 14,764,815.80 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,191,933.79 | 14,764,815.80 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **56,533,012.58** | **47,186,199.81** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **14,776,500.00** | **37,000,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **14,776,500.00** | **37,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 14,776,500.00 | 37,000,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 14,776,500.00 | 37,000,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(14,776,500.00)** | **(37,000,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 41,756,512.58 | 10,186,199.81 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 66,676,583.15 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 66,676,583.15 | 76,862,782.96 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **362,059,153.42** | **185,479,956.46** | **407,397,608.42** | **954,936,718.30** |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **362,059,153.42** | **185,479,956.46** | **407,397,608.42** | **954,936,718.30** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **362,059,153.42** | **185,479,956.46** | **407,397,608.42** | **954,936,718.30** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (101,663,795.88) | (101,663,795.88) |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **362,059,153.42** | **185,479,956.46** | **305,733,812.54** | **853,272,922.42** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,359,347,600.00** | **1,071,803,986.67** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,359,347,600.00 | 1,071,803,986.67 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,219,325,600.00 | 999,821,947.73 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 783,976,600.00 | 701,215,976.87 |
| 210101 | Үндсэн цалин | 273,735,300.00 | 348,641,891.03 |
| 210102 | Нэмэгдэл | 419,060,400.00 | 268,893,391.84 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,727,700.00 | 25,800,000.00 |
| 210104 | Урамшуулал | 86,453,200.00 | 57,880,694.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 97,769,200.00 | 85,159,242.47 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 65,853,400.00 | 61,804,675.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,979,000.00 | 7,293,838.01 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,989,500.00 | 3,551,225.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,989,500.00 | 2,501,847.26 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,957,800.00 | 10,007,656.67 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 36,553,800.00 | 34,192,584.20 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,211,600.00 | 4,602,666.64 |
| 210302 | Түлш, халаалт | 27,740,200.00 | 26,903,967.56 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,602,000.00 | 2,685,950.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 69,975,400.00 | 46,294,335.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 14,170,000.00 | 5,177,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 33,900,000.00 | 24,925,720.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,705,600.00 | 2,093,465.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,551,000.00 | 30,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 17,648,800.00 | 14,067,650.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 84,361,900.00 | 68,639,143.38 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 68,797,300.00 | 56,804,353.38 |
| 210502 | Хоол, хүнс | 9,564,600.00 | 6,114,790.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,000,000.00 | 5,720,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 90,119,200.00 | 30,756,799.81 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 58,323,800.00 | 20,431,939.81 |
| 210604 | Урсгал засвар | 26,595,400.00 | 10,324,860.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 11,500,000.00 | 9,062,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,500,000.00 | 9,062,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 25,719,500.00 | 17,390,166.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,079,800.00 | 15,162,666.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,050,000.00 | 1,500,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 150,000.00 | 79,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 150,000.00 | 109,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,689,700.00 | 539,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19,350,000.00 | 7,111,100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,350,000.00 | 7,111,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 140,022,000.00 | 71,982,038.94 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 140,022,000.00 | 71,982,038.94 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 91,538,000.00 | 36,150,038.94 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 8,484,000.00 | 8,484,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 40,000,000.00 | 27,348,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,359,347,600.00 | 1,081,990,186.48 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 42,553,800.00 | 37,192,584.20 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 42,553,800.00 | 37,192,584.20 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,147,518,600.00 | 997,586,782.28 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,147,518,600.00 | 997,586,782.28 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 169,275,200.00 | 47,210,820.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 102,598,700.00 | 47,210,820.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **66,676,583.15** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **76,862,782.96** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 25.00 | 23.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 15.00 | 17.00 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,827.9 мянган төгрөгийн алдаа[1] илэрч, санхүүгийн тайланд залруулах алдаа илэрээгүй.

Аудитаар залруулагдаагүй 6,827.9 мянган төгрөгийн зөрчил[2] илэрсэнд 1 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь 6,827.9 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 12,137.6 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**5.1 Төлбөрийн акт**

5.1.1 Орон нутгаас олгож буй байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй, эдийн засгийн ангилал зөрчин, байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардал болох, аж ахуйн материал, авто машины сэлбэгийн зардал санхүүжүүлж төсвийг зориулалт бусаар зарцуулсан 1,452.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”, хоёрдугаар хавсралт “Зардлын эдийн засгийн ангилалын тайлбар”-т Хэрэглүүрийн гуравт “ Төсөв боловсруулж батлуулах, гүйцэтгэлийн тайлан гаргах, зардлын хяналт, аудит хийхэд ашиглана”, Төсвийн захирагчийн үүрэгт “ Зардлын ангилалын тодорхойлолтод заасны дагуу нийцүүлж зөв бүртгэх, мэдээлэх, тайлагнах үүргийг төсвийн бүх шатны захирагчид хүлээнэ”, 2103 -д” байр ашиглалттай холбоотой тогтмол зардалын тодорхойлолт”, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо

**5.2 Албан шаардлага**

5.2.1 Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүйтэй холбоотой 1,719.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31.2-т “Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" , Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны 01/103 албан тоотын заалтуудыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

5.2.2. Тайлант онд эм боох материалыг сумын эргэлтийн эмийн сан болон тендерт шалгараагүй аж ахуйн нэгжүүдээс худалдан авалт хийсэн, тендерийн үнэ, шалгуур үзүүлэлт баримтлаагүй, аймгийн Эрүүл мэндийн газраас зарласан " Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" нийлүүлэх ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйтэй холбоотой зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32.1-д “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.”, ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээ болон гэрээний хавсралтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ

**5.3 Зөвлөмж**

5.3.1. Эм боох бараа материалын ангилалд тусгай зориулалтын бараа материал бүртгэсэн, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эмийн захиалга хийдэггүйгээс он дамжин зарцуулагдаагүй эмийн үлдэгдэл их, хугацаа хэтэрсэн эм, эмнэлгийн хэрэгслийг акталж устгах арга хэмжээ аваагүй,эм

боох материалын зарлага бүртгэхдээ эхэлж авсанаа эхэлж зарлагадах аргыг хэрэглээгүйтэй холбоотой 2,096.9 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.5.4 –д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;”, 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” , Сангийн сайдын 2025 А/03 тушаал Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн журмын хавсралтын 8 зүйлийн 8.2.-д “Бараа материал нь түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, хангамжийн материал, нөөцийн бараа, бусад бараа материал бүрдэнэ.”, 8.3.-д” Бараа материалыг УСНББОУС 12 "Бараа материал"-ын дагуу бүртгэнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Эм боох материалын бүртгэлээс, тусгай зориулалтын материалыг данс хооронд шилжүүлж бүртгэх.

5.3.2 Үндсэн хөрөнгө орлого авахдаа санхүүгийн программд ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 1 нэр төрлийн 1,560.0 мянган төгрөгийн хөрөнгөд элэгдэл тооцоогүй зөрчил илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын хавсралтын 10 дугаар зүйлийн 10.24-д "Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлнэ", 10.26--д "Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглахаар тооцсон үлдсэн хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жил бүрийн эцэст хянаж, тооцооллын өөрчлөлтийг гүйцээх горимоор бүртгэнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Дараа тайлангийн хугацаанд дээрх хөрөнгүүдийн элэгдлийг орлогод хүлээн авсан онуудаас эхлэн нөхөж тооцон холбогдох данс бүртгэлд залруулга хийх.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу шийвдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Архангай аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүй | 1 | 1,719.00 | | | 1 | 1,719.00 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тайлант онд аймгийн Эрүүл мэндийн газраас зарласан " Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл"нийлүүлэх ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, | | | | | | 0.00 | | |
| Эм боох бараа материалын ангилал буруу бүртгэсэн, он дамжин зарцуулагдаагүй эмийн үлдэгдэлтэй, хугацаа хэтэрсэн эм, эмнэлгийн хэрэгслийг акталж устгах арга хэмжээ аваагүй, | 1 | 2,096.9 | | | | | 1 | 2,096.9 |
| Орон нутгаас олгож буй байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг зориулалт бусаар зарцуулсан | 1 | 1,452.0 | 1 | 1,452.0 | | | | |
| Санхүүгийн программд үндсэн хөрөнгө бүртгэхдээ ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 39 нэр төрлийн 42.5сая төгрөгийн хөрөнгөд элэгдэл тооцоогүй, | 1 | 1,560.0 | | | | | 1 | 1,560.0 |
| **Дүн** | **4** | **6,827.9** | **1** | **1452.0** | **1** | **1,719.0** | 1 | **3,656.9** |